

## VIII БОГДЫН АЙЛДСАН “АЯА ГАЙХАМШИГТ” ХЭМЭЭХ ЛҮНДЭН СУРГААЛИЙН ГУРВАН ХУВИЛБАРЫН ТУХАЙ

Ж.Болдбаатар, Э.Жигмэддорж

\*Монгол улсын их сургууль, Нийгмийн шинжлэх ухааны сургууль, Түүхийн тэнхим.  
[jigmed\\_e@hotmail.com](mailto:jigmed_e@hotmail.com)

**Өгүүллийн товч утга:** Богд Жибзундамба хутагтын үе дараалан айлдсан лүндэн сургаалиуд нь Монголын түүх, нэн ялангуяа шашин, соёл, бичгийн сурвалж болохын хувьд судлаачид шинжээчдийн анхаарал татаж, олны хүртээл болсоор иржээ. Тэдгээр хэрэглэгдэхүүн нь зохиогдсон тухайн цагийн түүхийг зэрэгцүүлэх боломж олгохын зэрэгцээ хойч үеийнхэн санаа авууштай сургамж ухаарал хайлласан ёс суртахууны гүн гүнзгий утга агуулгатай байдаг. Ийм учраас VIII Богдын айлдсан “Аяа гайхамшигт” хэмээх лүндэн сургаалийн гурван хувилбарыг харьцуулан шинжилж уншигч Танаа толилуулж байна.

**Түлхүүр уг.** VIII Богд, лүндэн, сургааль, соёл, судар, бичгийн дурсгал, бурхан шашин, ёс суртахуун, шашны түүх

Монголын их хаад, хутагт хувилгаад, эрдэмт мэргэдийн айлдсан сургааль, лүндэн, онч мэргэн үгс нь монголын ард түмэн, бидний өвөг дээдсийн маань уламжлан үлдээсэн оюуны үнэт өв болно.

Бид энд VIII Богдын айлдсан “Аяа гайхамшигт” хэмээх лүндэн сургаалийн гурван хувилбарыг харьцуулан үзсэнээ та бүхэнд толилуулахыг хичээсэн юм.

Энэхүү сургаалийн эдүгээ олдоод байгаа гурван эхийн **нэгдүгээр** нь Булган аймгийн Хишиг-Өндөр сумын “Гандан-Даржаалин” хийдийн хамба лам С.Цэрэндагвад хадгалагдаж байна\*. Энэ эх Төвдөөр бичсэн, сударчилсан хэлбэртэй, цаасны хэмжээ 22x9 см, 9 цаас (хуудас), 18 тал, “Олон даяар тараалгуулсан VIII Богдын сургааль номлосон судар” хэмээх нэртэй, үг үсэг тод гаргацтай ажээ. Үүнийг тэрбээр шинэ үсэгт буулгаж өгсөн амуй.

**Хоёрдугаар** нь мөн С.Цэрэндагва гуайд байгаа бегөөд монгол бичгээр муутуу цаасан дээр нугалбар маягаар бичсэн гар бичмэл, цаасны хэмжээ 26.5x9.5 см, “Очир дарь Богд гэгээн таны лүндэн сургааль оршив” гэсэн гарчигтай, зарим нэг үг үсгийг баллан засаж бичсэнээс гадна муутуу цаасыг дунд нь холбож наасан үзэгдэнэ.

**Гуравдугаар** нь С.Бадарчийн хувийн цуглуулгад буй. Үүнийг Г. Жамсранжав, Н. Дугарсүрэн нар “Богдын лүндэн” (УБ., 2002) бүтээлдээ бүрэн эхээр нь нийтэлжээ<sup>1</sup>. Уг эх “Очир дарь Богд гэгээний VIII дүрийн аяа гайхамшигт лүндэн оршвой” гэсэн гарчигтай, өмнөх хоёр эхээс үг хэллэгийн хувьд харьцангуй ялгаатайгаараа онцлог аж.

**Богдын сургаалийн гурван янзын хувилбар байгаа нь түүнийг Ар халх, нийт Монгол даяар өргөн тархаж байсны илрэл бололтой.** Негөө талаар бид энэхүү сурвалж бичгийн анхны эхийг Төвд хэлээр байсан болов уу? хэмээн таамаглаж байна. Учир юун гэвэл түүхийн бусад холбогдох баримт сэлтээс үзэхэд Богд Жибзундамба хутагт өөрийн сургааль лүндэн зэргийг ихэвчлэн Төвдөөр бичиж (айлдаж) түүнийг нь бичгийн мэргэд худам монгол бичгээр хөрвүүлэн олны хүртээл болгож байсан гэдэг. Тиймээс үүнийг анхлан Төвдээр бичсэн байж тун магадгүй. Өөрөөр хэлбэл, эдгээр гурван эхийг монгол хэлзээрхи хувилбар эхүүд хэмээн үзэх нь зүйд нийцэх буй за.

\* С.Цэрэндагва гуай эдүгээ 90 шахсан, Булган аймгийн Хишиг-Өндөр суманд амьдарч байна. Сайхн хүмүүн монгол, төвд бичигт цагааширсан, гүн бясалгал бүхий нэгэн. Тэрбээр насан огшсон боловч бие цэгц, ухаан саруул, тавлаг тавиун аж төрж, насан залуугаас хуримтлуулсан билэг оюунаа хаялгаа олонд хүртээж, буян номоо арвижуулсаар байна. Тэрбээр эл өгүүлэлийг тэрлэгчийн нэг Э.Жигмэддоржийн авга өвөг эцэг болой.

<sup>1</sup> Жамсранжав Г, Дугарсүрэн Н. Богдын лүндэн. УБ., 2002. 9-14 тал

Сурвалжийн зохиогдсон он цагт холбогдох мэдээ Төвд хувилбарын гарчигт буйг сийрүүлбээс: "Бадаргуулт төрийн хорин наймдугаар он, гурван сарын турванд VIII Богд гэгээн сургаалыг зарлиг болговай" гэжээ. Үүнийг Манжийн хаадын он дараалалтай харьцуулан үзвэл Бадаргуулт төрийн 28-р он нь аргын он тоололын 1902 он болж байна. Харин бусад хоёр хувилбарт энэ талаар дурьдсан ямар нэг баримт үгүй. Тэгэхээр дээрх мэдээг эш үндэс болговоос Богд гэгээн энэхүү сургаалиа 1902 онд айлдажээ гэдэг нь тодорхой болж байна.

Дурьдан буй лүндэн сургаалийн гурван хувилбарыг тулган үзвээс тэдгээр нь уг хэллэг, бичиглэл зэргээрээ зарим нэг ялгаатай байх агаад харилцан бие биенээ нөхсөн шинжтэй байна.

Үг хэллэгийн тухайд гэвэл юуны өмнө сурвалжийн гарчигт үг, үсгийн зөрүү үзэгдэж буй. Тухайлбал; 1-р хувилбарт "Олон даяар тараалгуулсан VIII Богдын сургааль номлосон судар", 2-р хувилбарт "Очир дарь Богд гэгээн таны VIII дүрийн лүндэн сургааль оршив", 3-рт Очир дарь Богд гэгээн таны VIII дүрийн Аяа гайхамшигт лүндэн оршив" хэмээн бага зэрэг зөрүүтэй нэрлэсэн байна. Эндээс Богдын сургаалийн уг нэр нь "Аяа гайхамшигт" хэмээх лүндэн байсныг мэдэх бололцоо олдож буй.

Мөн зарим үг, үсгийг өөрөөр бичсэн тохиолдол цөөнгүй тааралдаж байна. Тухайлбал; Төвд хувилбарын "Би нэгэн зуун хорин нас наслахын тухайн тулд насалбай" гэсэн өгүүлбэрийг 3-р хувилбарт "Би нэгэн зуун хорин нас наслах нь дамжигүй намтартай тул насалсугай" гэжээ. Сурвалжид энэ мэт мэр сэргээр өөрөө буй нь хуулбарлан бичигч бүр өөр өөрийн барил, хэллэгийн өвөрмөц байдлаар илэрхийлж байсантай холбоотой бололтой.

Гурван хувилбар нь харилцан бие биенээ нөхсөн шинжтэй байна гэдгийг дээр дурьдсан. Үүнд: 1-р хувилбараас сурвалжийн зохиогдсон он цаг, 2-р хувилбараас төгсгөлийн уг буюу өрөөлийн уг, 3-аас лүндэн сургаалийн уг нэр зэргийг тодруулан үзэж болно.

Мөнхүү сурвалжид түүхийн зарим мэдээ буйг сийрүүлбэл "Ар халх мину би тавдугаар, зургадугаар, долдугаар, наймдугаар Богд гэгээн гэж олон олон төрөлдөө олон удаа сургаалыг гаргасан билээ"<sup>2</sup> гэжээ. Үүнтэй холбогдуулан нэгэн зүйлийг хэлэхэд С. Цэрэндагва гуай V Богдын айлдсан лүндэн сургаалийг эдүгээ хүртэл эрхэмлэн хадгалсаар байгаа ажээ.

Дурьдан бүхий З хувилбарын үндсэн утга агуулга өрөнхийдөө ижил байгаа бөгөөд тэр нь тухайн үеийн Халхын ард түмний аж байдал, хүмүүний ёс суртахуун хийгээд улс нийтийн шинжтэй зүйлүүд тухайлбал; Бурхан шашнаа дээдлэн хүндэтгэх, өөрсдийн сэтгэл оюуныг хөгжүүлж, буяныг арвижуулж, бузарыг цээрлэхийн ач тусыг сэнхрүүлэн ухааруулахад чиглэгдсэн сургааль юм. Юуны өмнө, эв найртай байж, ээ эвээ хичээн, хэрүүл шуугиангүй энх амгалан аж төрөхийг уриалжээ.

Сурвалжийн агуулгыг дараах байдлаар ангилан үзэж болно. Үүнд:

1. Ард олны аж төрөхүйн сургааль
2. Тэднийг аливаа муу үйл хийхээс сэргийлэх, амирлуулах асуудал
3. Бурхан шашин, лам хуваргын тухай
4. Хүмүүний ёс суртахуун, зан байдлын тухай
5. Сургаалийн хүч чадал, ач тус зэрэг өргөн хүрээг хамарсан хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий зүйлийг өгүүлжээ. Тухайлбал; Лүндэнд "... Та нарын татсан тамхины утаа нь отторгуйн наран сарны гэрлийг бүрхэх цагт хүрч байна. Таны уусан архи чинь далай мөрөн мэт болж гэтлэн гаршгүй болж байна. Энэ цөвүүн цагт багаан тамхины үр дэлгэрч байна биш үү? Тэр цагт цагаан тамхины үнэнд алт, мөнгө өгч татна, түүний хойно арван буянтай үр хүүхдээ өгч

<sup>2</sup> Сургаалийн Төвд хувилбараас эшлэв.

татна, түүний сүүлд нүдээ өгч алтан амия алдана биш үү?"<sup>3</sup>, "Ар халх мину баян гэж бүү бард, баахан хоосон гэж бүү гомд, баян чинь ганц довон дээр, баахан хоосон чинь ганц усан дээр, бардам омог чинь ганц суманд аа"<sup>4</sup> гэсэн нь эдүгээ эмс охид тамхинд орж, хар тамхины аюул нүүрлэн, баян, хоосны ялгаварал хүчтэй болж буй үед нэгийг бодогдуулахуйц чухал сургамж хайрлаж хэрэг болой.

**Богд гэгээн ийнхүү сургааль айлдах болсон учир нь түүхэн тухайн цаг үеийн Монголын нийгэм, оюун санаа, шашин суртлын байдалтай нягт холбоотой байжээ.**

Тухайбал, Лүндэнд өгүүлсэн гэргий хүний дэргэр үс, суман дэл (сэргэр мөр), алт, мөнгийг 5 цэнгээс илүү эдлэхгүй байх зэрэг санаа хожим Ардын засгийн газрын "Эхнэрүүдийн өндөр үс самнах ба зүүлт эдлэлийн талаар гаргасан тогтоол" (олноо өргөгдсөний 2-р он, XII сарын 14 –ний өдөр) –д тусгалаа олжээ. Тэрхүү тогтоолд "...Засгийн газраас эхнэрүүдийн өндөр үс самнахыг цаазалж, зүүх эдлэлийг таван лангаар хэмжин тогтоож зарласан ..."<sup>5</sup> гэсэн нь сургаалийн агуулгатай ямар нэг хэмжээгээр холбоотой.

Сурвалжид "Энэ цөвүүн цагт цагаан тамхины үр дэлгэрч байна биш үү?" гэсэн нь архивын болон түүхийн бусад баримттай дүйж байгаа юм. Тодруулбал, Хар тамхи Монгол газар ихэд нэвтэрч байсан явдалд олон түмэн дургүйцэн түүнийг хориглох, цаазлах ажаамуу хэмээн дээд эзнээ нугалбар өргөн барьсанд Богд хаан ёсоор болгожээ. Түүнд "Хар тамхи хэмээгч болбоос хамаг хортой бузар юм мөн тул, хүн татаж хэрэглэх ба худалдааны үүс дотор газраас авчирч худалдан өгөх, манай Монгол улсын тарианд тарих зэрэг явдлыг нэгэн адил чангалаан цаазалсугай"<sup>6</sup> хэмээжүүхүй. Түүний зэрэгцээ тухайн үед Монголд оршин сууж асан Солонгосын 5 иргэн Алтанбулагийн газар хар тамхи зөвшөөрөлгүйгээр тариалж, улмаар засгийн газраас шийтгүүлж байсан тохиолдол буй<sup>7</sup>. Энэ мэтээс өнгөц харахад, бидний өгүүлэн байгаа сурвалжийн дээрх мэдээ хэдийгээр товч, багавтар боловч цаашид нарийн судлууштай, түүхийн чухал ач холбогдолтой зүйл болох нь гарцаагүй.

Мөн энд "Шинэ засгийн бодлого"-ыг хэрэгжүүлж, Хятадын нөлөөг ихэсгэх нь Монголд олон зууны туршид уламжлагдан ирсэн **Буддын шашны нөлөөг бууруулах алхам** болж байсныг харгалзан үзэх нь зүйтэй болов уу? Өөрөөр хэлбэл, Манжийн төрийн энэ мэт бодлого шашны ихэс дээдэс, лам хуварга, нийт олны сэтгэл санаанд төдий л хурсэнгүй. Тиймээс ч сургаальд "Лам багшийг сайн санаж шүтэн эвсэлдэх шалтгааныг хичээ. Тангараг санваар хоёрыг сайн авч явбал бурханы оронд очиход хол үгүй биш үү?" хэмээн олонтаа өгүүлжээ. Энд багшийг шүтэх ёсон нэн эрхэм гэж үзжээ.

Эдгээр үндэслэлүүд нь сурвалжийн түүхэн үндсийг мөшгөх гэсэн бидний бүдүүн баргийн оролдлого гэдгийг анхаарах буй за.

#### **Дээр өгүүлсэн зүйлүүдэд үндэслэвэл;**

- Богдын айлдсан энэхүү лүндэн сургааль бол түүний зүгээс нийт хүмүүний тусын тулд сэтгэл оюунаа чилээн байсны бодит гэрч, үр дүн мөн.

- Лүндэн сургааль эх бичгийн хувьд хэмжээ адилгүй, одоогоор олдоод буй 3 хувилбар харилцан бие биесийг нөхсөн шинжтэй, гарчиг болоод зарим үг үсгийг

<sup>3</sup> Гуравдугаар хувилбараас эшлэв

<sup>4</sup> Энэ өгүүлбэр хоёрдугаар хувилбарт буй

<sup>5</sup> "Түүх-Баримт" (цувлал №1). УБ., 1994. 5 сар, 14-р тал

<sup>6</sup> "Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл". Баримт бичгийн эмхтгэл (1900-1911). УБ., 1982. 239-р тал

<sup>7</sup> Баттөр Ж. ХХ зууны Монгол – Солонгосын харилцаа. Тэргүүн дэвтэр (1910-1930-аад он) УБ., 2000. 177-р тал

өөрөө бичсэн тохиолдол цөөнгүй үзэгдэх нь түүнийг нийт олон даяар тархааж (түгээж) байсны улбаа бололтой.

- Нөгөөтэйгүүр үүнийг сургааль, лүндэнг хуулбарлан бичигч тус бүрийн арга барил, хэллэгийн өвөрмөц онцлогтой холбон ойлгож болно.

- Уг сурвалж нь Монголчуудын ном судар, лүндэн сургаалийг хэвлэн олшруулах, олон түмэнд түгээн дэлгэрүүлж байсан өвөрмөц арга ухаан, бичгийн хэв, олон янзийн цаас, үзэг бийр хэрэглэж ирсэн арвин их уламжлалыг улируулан үзэж болохуйц үнэт баримт юм.

- Богд гэгээний үе дараалан айлдсан лүндэн сургаалиуд тухайн түүхэн үеийнхээ Монголын түүх, түүн дотороо шашин сурталын түүхэнд холбогдох чухал сурвалжууд болох учраас тэдгээрийг цаашид эрэн сурвалжилж, судлан шинжлэх нь зүйтэй байгааг онцлон тэмдэглье.

Бид сургаалийн харьцуулсан эхийг дор нийтлүүлж байна. Үншигч та мэргэн оюундаа тунгаах ажаамуу.

**Жич:** Сургаалийн харьцуулсан эхийг хэвлэлд бэлтгэхдээ Түvd хувилбарыг баримтлан нөгөө хоёр хувилбарт тухайн үг, үсгийг өөрөөр бичсэн бол үндсэн үгийн хойно <> хаалтад хийж зүүлтэнд ямар хувилбар болохыг заав. Басхүү Түvd хувилбарт отг байхгүй үгийг бусад хоёр хувилбараас нөхөж бичсэн болно. Үүнд 2-р хувилбарт байгаа үгийг ( ) хаалт, 3-р эхэд буйг дээрхээс ялан // хаалтад тус тус бичив.

### “Олон даяар тараалгуулсан VIII Богдын сургааль номлосон судар”

Бадаргуулт төрийн хорин наймдугаар он, гурван сарын шинийн гурванд VIII Богд сургаалыг зарлиг болговай.

Ум сайн амгалан болтугай !

Сувасадын орноос бууж ирсэн  
Баруун зүгийн Далай ламаас зарлигтай  
Банчин боддоос сунтагтай<sup>1</sup>

Далан таван Махгалын дүртэй  
Мянган мэлмийтэй, түмэн сонортой

Хоншин бодь сад Очирдарь ламын гэгээн гэж Ар халх, /Дөрвөн аймаг, Шавь долоон хушуу, Өвөр дөчин есөн хушуу хийгээд / Хушуунд залагдаж ирсэн билээ би. Богд хаанаас зарлигтай Ар халхын ширээнд суусан билээ. Шашныг дэлгэрүүлж, шашны алтан тамгыг түшиж, эх болсон зургаан зүйл, хамаг амьтны тусын тулд амирлангуй дүртэй сууж, Ар халхдаа өдөр, шөнийн хамт замбуу тивийг товчилон зургаа эргэдэг билээ.

Ар халх та нар мину: гэр дотор хэрүүл шуугиан /тэмцэл/, хэл ам, /атаа/ тангараг, /гальн манаа/ андгайлал маань, үүдний шороо хог чинь халж орж болохгүй байна.

Ар халх та нар мину: арван зургадугаар оны (Бадаргуулт төр хааны 17-р он Төмөр туулай жилийн) өвлийн адаг сарын хорин есөнд Дэчингалав, Очирдарын их лавиран /Хийд/ орон балгас /ыг золионд өгч та нарын алтан амыг аварсан билээ/ та нарын алтан амь бие тань /чинь/ завсарлаж золионд өгч хальсан биш үү.

Ар халх та нар мину: хийсэн хилэнц, үйлдсэн нүгэл чинь миний зүүн, баруун алган дээр эрлэгийн хааны толь мэт илхэн байна. Та нарын татсан тамхины утаа нь огторгуй, нар, сарны гэрлийг бүрхэх цагт хүрч /ирж/ байна. /Таны/ уусан архи чинь далай мөрөн мэт болж гэтэлж <<гаталж>><sup>2</sup> гаршгүй болж байна. /Энэ/ цөвүүн цагт цагаан тамхины үр дэлгэрч тарна <<гарна>><sup>3</sup> биш үү.

<sup>1</sup> Сунтаг – гэж утас буй. Банчин бодын сунтаг (увидас)-ыг атгасан гэсэн утгатай болой. Сунтгийн адис хүртэнэ гэдэг нь шууд гараас бус, гараас нь уясан утаснаас гаднаас барьж, адис хүртэнэ гэсэн утга болой.

<sup>2</sup> Гуравдугаар хувилбар.

<sup>3</sup> Мөн тэнд

Тэр /цагт/ цагаан тамхины<sup>4</sup> үнэнд алт мөнгө, эд таваар өгч татна, тэрний сүүлд <<түүний хойно>><sup>5</sup> арван буян /-тай/ үр хүүхдээ /даяар/ өгч татна, тэрний сүүлд нүдээ ухан өгч, алтан амиа алдана биш үү. Хойт төрөл чинь гурван мянган галавыг нөхцтөл Очирдарь тамын зовлонг /үзнэ/ эдлэнэ биш үү.

Хуучин бар жил, хуучин туулай жилийг үзвэл жаран жилийн жаргал үзнэ биш үү. Гэвч та нар мину үйлдсэн арван хар нүгэл, хар улаан хараал чинь /таны/ энэ цөвүүн цагт хар, улаан ханиадны эзэн болж айсуй явна /биш үү/. Тэрний хориолол болгож, аливаа муу юмыг амирлуулахын /амирлуулж байхын/ тухайд өрх гэр дараалан /бүгдээрээ тасралтгүй/ Сундуй, Жадамба, Лүмбэн гарав, Таравцанба, Дамдингын дорь дүв /тордог/, бага, сага айл /болвоос/ Алтангэрэл, Дашзэгвэ, Найман гэгээн, /Нанзад/, До дүдба, Доржодов, Намсрайн даллага, лам хуврага хүмүүс /ны/ Гүрэм нам гүм (Гурван гүрэм Э.Ж.), Дэвжид сэргжим, Жамбал цанжид, Жамсрангийн шаваг, нийт хар шар бүгдээрээ /давараа/ маань, мэгзэм, /Дарь эх/, Жанлавцогзол, Базарсадыг түм бүм үншигтун <<унш>><sup>6</sup>.

Ар халх мину, Гурван настай хүүхдээс дээш /нийгэм/ хүмүүнүүд ертөнцийн жам ёсоор /аж төрөл/ арилжаа наймаа, архи, /тамхи/, даалуу, /шагай хөзөр/, арван зүйлийн нүгэлт явдал болгоныг өдөр, шөнийн зургаан цагт юутай сайныг мэдэж чадаж байдалаа (эрдэмт хүмүүний биеийг олсон зарим та нар мину шажинтай газарт) эрдэм номыг юунд эс /уншнам/ үзэв дээ (сурав). Маань мэгзэм юунд (эс) буруушаав даа (хэрэглэв), хойд насандаа бурхны оронд яаж учрах сан билээ.

Ар халх мину: би тавдугаар, зургадугаар, долдугаар, наймдугаар Богд тэгээн гэж олон дүрд /төрөлвөө/ олон /энэ/ сургааль /-ыг/ гаргасан билээ. Та нар мину сонсов чиг сонсоогүй шиг /мэт/, үзэв чиг үзээгүй юм шиг, харав чиг хараагүй юм шиг, тоомжиргүй /эхийг өгүүллийн ард хавсаргав/ тоохгүй олныг өнгөрүүлсээр ирсэн билээ.

Ар халх та нар мину: алт мөнгийг /их/ зүүж эдлэвээс амны хишиг /заяаны/ буян чинь зайлна <<зайлах>><sup>7</sup> бишүү. Хойт насанд (төрөлд) чинь тамын хадаас (болж) биеэнд чинь гинж болж байна. Энэ цөвүүн цагт (могойгоос морин жил хүртэл авгай хүмүүн) алт мөнгийг 5 цэнгээс илүү бүү эдлэ, Миний үгнээс зөрж /зэрчиж/ эдлэвээс аливаа муу хортон дайсны гарт түргэн орж <<учирч>><sup>8</sup> зовно /явах/ биш үү.

Ар халх мину: Манж хүмүүн, хар хятадыг ирэхэд ширээгээ тавьж, ширдэгээ дэвсэж миний шашны хуваргуудыг доромжилж, дорд зах газар суулгаад, зөв буруу үгийг ярилцан дооглон суудаг чинь бурхан шажинтай эвдэрч, хэл буруу дайсны <<этгээдийн>><sup>9</sup> гарт түргэн учирч зовно явах буй. Хойт төрөл чинь гурван мянган /ертөнцийн/ галавыг нөхцтөл Очир дарь тамын зовлонг эдлэхийн тохио, гэлэн гэцэл, тойн хуваргууд минь хурал номын газраас орхимжoo бүслээд цэвираа хийсгээд, улаан шарлаж алаглан, морийг худалдаж, унаж байна.

Бага идээгээ ам барьж, авгай хүүхнүүдэд дооглуулж <<доог болж>><sup>10</sup> явдаг чинь миний нүдэнд илхэн. /Шарын/ шажин чинь үүлний сүүдэр дайрч өнгөрдөгтэй адилхан болж байна.

Энэ цөвүүн цагийн авгай хүмүүн нарын хийдэг дэргэр үс ба суман дэл /сэргэр мөр/ чинь миний нүдэнд шувуун толгойтой, эрлэгийн элч лугаа адил /болж/ үзэгдэж байна.

<sup>4</sup> Энэ нь Хар тамхийг хэлжээ

<sup>5</sup> Гуравдугаар хувилбар

<sup>6</sup> Гуравдугаар хувилбар

<sup>7</sup> Мөн тэнд

<sup>8</sup> Мөн тэнд

<sup>9</sup> мөн тэнд

<sup>10</sup> Хоёрдугаар хувилбар

Далай ламаас зарлиг болсон /заасан зарлигтай/, Банчин боддоос урласан /ершөөсөн/ алтан тамгыг /та нарын/ орой /дунд/ чинь адис болгож дарж өгье гэж санавчиг ер болшгүй. Энэ цөвүүн цагийн хүүхэн бүсгүй <<бүстэй, бүсгүй хүн>><sup>11</sup> хүмүүн нарын /хийдэг/ гээг үсний залгаа чинь /миний нүдэнд/ хар эрээн могой болж үзэгдэж байна. Аав, ээжийн хайлласан /хийсэн/ хонгор /халиун/, улаан хар үс нь /байтал/ элдэв этгээдийн муу юмыг юунд эс зүүнэ дээ.

Энэ цөвүүн цагт битүү саравчтай, бөмбөгөр <<бөөрөнхийй>><sup>12</sup> оройтой малгай өмсөж /эдэлвээс/ элдэв эсийн миний нүдэнд цэрэг хувцас, сумны толбо шинжтэй болж үзэгдэж байна. Улаан ташуур барьдаг чинь <<бариваас>><sup>13</sup> гар хуруугаа цусдахын дохио (байна), улаан хуйтай хутга зүүвээс улаан ташаатай болж илд <<ирт>><sup>14</sup> мэсэнд дайрагдахын дохио, улаан эмжээртэй гутал өмсөж эдэлвээс хонго боривоо сэнжлүүлэх, түрүү боривоороо цус нөх асгаруулахын <<дүүрэхийн>><sup>15</sup> тохио, дөрөөвчин гелөм тоховоос суварганы толгойг доош нь харуулсан мэт болж бурхан шашинаасаа буруутахын дохио, /гэрийн/ харцуул, авгай хүмүүн нар шар улааныг эдэлж, доромжилж эхэлдэг чинь бурхан шашинтай эвдэрхийн тохио, эрлэг тамын газар учрах болно биш үү.

Ар халх та нар мину: мянган хонио хотолж /худалдаад/, мянган лан мөнгийг авдартлаж, буян номыг үйлддэг үгүй /Бусдын буян үйлдэхэд дагаж баясалцахгүй/, хоосон өгдөг өгөхгүй явж эцэс хойт төрөлдөө бурхны оронд яаж учрах юм бэ?. Бусад хойт төрөлдөө эрлэг тамын газар учрахдаа /очихдоо/ /аянга/ мянган хонийг туугаад, мянган лан мөнгийг дэнслээд аюулыг гэтлэхэд хөгшин запуу /үхэхийн цагт чөлөөгүй/ гэдэг үгүй шүү. Үхлийн эзэн магад ирэхийн тэр цагт алтан /сайхан/ амийг завсарлаж /байхын/ тухайд буяныг үйлдэж, нүгэлийг тэвчиж явах маань явав даа. Аюулт их дайсан учирч довтолж зүхэж байхыг зогсоож байдаг билээ.

Ар халх та нар мину: баян гэж бүү бард, баахан хоосон гэж бүү гомд, баян чинь ганц довон дээр, баахан хоосон чинь ганц усан дээр, бардам омогтой чинь ганц бууны суманд аа.

Ар халх та нар мину: одоо энэ цөвүүн цагт энэ сургааль номонд эс орвоос тэнгэрийн дууны аюул, галын аюул, /үер/ усны аюул /эрэх биш ирнэ/, нэртэй нэргүй гэнэт үхэх аюул зовлонд учрах байна биш үү. Миний энэ сургаалийг гэрийн дотор нэг дуудваас гэрийн барцад сэтгэл /түйтгэр/ магад арилна. Хоёрдугаар уншваас ... барцад магад арилна. Гурван удаа дуудваас гурван муу заяанд учрах үгүй, гурав гурван төрөлдөө дахин дахин бурханы оронд учирч /надтай учирч/ төрнө бишүү.

Миний энэ сургаалийг дагаж явсан лам хуврага хүмүүнийг лам багш мэт санъя. Гандан диваажингийн оронд гэлэн гэцэл болгож төрүүлье. Миний энэ сургаалийг дагаж явсан харцуул, авгай бүсгүй бүгдийг эцэг, эх мэт бодьё, Манзушир бурхан мэт санъя, Огногийн /Умрын/ оронд тойн хуварга болгож төрүүлье.

Миний энэ сургаалийг дагаж явсан лам нар ба ах дүү, авгай, дагинасыг миний дүү мэт санъя, Сухаваадийн оронд долоо /далан/ долоон төрөлдөө шадар сайн /шавы/ хүмүүн болгож төрүүлье.

Ар халх мину: энэ цөвүүн цагт миний энэ сургааль номонд орж явбаас аливаа муу хортон дайсныг үзэхгүй, аюул болгоноос гэтлэж гарах байна биш үү. Энэ цөвүүн цагт лам багшийг /сайн/ санаж шүтэн эвсэлдэх шалтгааныг хичээ. Тангараг, санваар хоёрыг сайн авч явбал бурханы оронд очиход хол үгүй биш үү.

<sup>11</sup> Гуравдугаар хувилбар

<sup>12</sup> Мөн тэнд

<sup>13</sup> Мөн тэнд

<sup>14</sup> Мөн тэнд

<sup>15</sup> Мөн тэнд

Миний энэ сургаалийг дуудсан сайн хүмүүнийг дуулж үзэж сонсвоос арван тавны сарны гэрэл мэт, оюунтай сайхан цэцэн мэргэн ухаантан болж Ганжуур, Данжуур хоёрыг орчуулгаар нь уншсантай адил биш үү. Мунхаг хүмүүн сонсвоос харанхуйшиж /шөнө/ хар усыг үнсэн дээр асгасан лугаа адил мэт. Аав, ээжийгээ өргөмжлөн хүндлэж явбаас хоёр насандаа амны хишиг, заяа буян /үргэлж/ дэлгэрч жаргана. Эв тангараг, хэрүүл шуугианыг чандлан хичээж явагтун.

Миний энэ сургаалийг гэрийн дотроо тахиж уншиж явсан хүмүүн турван жилийн гай <<барцад>><sup>16</sup> магад гарна /арилна/, дамжиггүй шүү, хуурмаг үгүй шүү.

Миний сургаалийг дуулсан сайн хүмүүн бодож санаж явагтун. Миний сургааль номлосон судар номыг олон даяараа айл алгасалгүй /айл бүрт/ албачлан чандлаж, шүтэж явбаас аливаа муу хортон дайсантай учрахгүй <<уулзахгүй сайн явна>><sup>17</sup>, амгалан болон жаран жилийн жаргал ирнэ. Арван хуруу тэгш жаргана.

Миний энэ сургаалийг дагаж явсан шавь нар минь надтай Гандандиваажингийн оронд дахин дахин учирч төрнө биш үү. Миний үгэнд орохгүй бол миний хойноос агт морио сульдаж, атан тэмээ эцээж, амь биеээ сүйтгэж очих (алсын газар ирсэн чинь) хэрэггүй.

Би нэг зуун хорин насыг наслахын тухайн тулд насалбай <<наслах нь дамжиггүй намтартай тул насалсугай>><sup>18</sup>, өдөр шөнийн хамт зургаа эргээ, өглөө эрт бос, үдэш орой унт /унттугай/, буяныг үйлд, нүгэлийг тэвч /орой бүр ерөөлийг тавьтугай/.

Очирдарь Богд гэгээний 8-р дүрийн гайхамшигт лүндэн оршивой.

(Ерөөл хутаг орших болтугай, санасан бүгд энэ номын ёсоор гүйцэлдсүгэй.)

Ум мани бад ми хум

Ум мани бад ми хум

Ум мани бад ми хум ./

<sup>16</sup> Гуравдугаар хувилбар

<sup>17</sup> Мөн тэнд

<sup>18</sup> Гуравдугаар хувилбар.

**Abstract:**

We have charged with 3 versions of 8 th Bogd is prays, tried to show their special feature 3 differences for these we have used basic method is of the sources material. And published with a compared edification.

**Ном зүй**

1. Батсүрэн Ц. Эх бичиг судлах онол, арга зүйн асуудалд. Хэл зохиол судлал. Том XX. Fas 19, УБ., 1987.
2. Баттэр Ж. ХХ зууны Монгол – Солонгосын харилцаа. Тэргүүн дэвтэр (1910-1930-аад он) УБ., 2000
3. Жамсран Л. Монголчуудын сэргэн мандлын эхэн УБ., 1994
4. Жамсранжав Г, Дугарсүрэн Н. Богдын лүндэн. УБ., 2002.
5. Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтолын төлөө тэмцэл". Баримт бичгийн эмхтгэл (1900-1911). УБ., 1982
6. Сэргээ Ж. Монгол бичгийн дурсгалт хийх эх бичгийн судалгааны зарим асуудал. Хэл зохиол судлал. Том XX. Fas 19, УБ., 1987
7. Түүх-Баримт (цувлал №1). УБ., 1994. 5 сар
8. Олон даяар тараалгуулсан VIII Богдын сургааль номлосон судар (Уг судар Булган аймгийн Хишиг-Өндөр сумын Гандан-Даржаалин хийдийн хамба лам С. Цэрэндагвад хадгалагдаж буй, Түвд хувилбарын нэр болой).
9. Очир дарь Богд гэгээн таны VIII дүрийн лүндэн сургааль оршив (Энэхүү судар Монгол бичгээр бичсэн бөгөөд эдүгээ зохиогчдын хувийн архивт буй).
10. Өвгөн Жамбалын яриа. Дамдинсүрэн Ц. Бүгд зохиол. УБ., 1998